



ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН УРЬДЧИЛСАН СУДАЛГАА ХИЙХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Засгийн газрын 2010 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам”-ын 2.7-д заасныг үндэслэн энэхүү “Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх аргачлал”-ыг боловсруулав.

1.2. Энэхүү аргачлалын зорилго нь “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” /цаашид УХОХ гэх/-ийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад чиглэгдэх бөгөөд төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны хамрах хүрээ, агуулга, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлоход чиглэгдэнэ.

1.3. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа нь хөрөнгө оруулалтын төслүүдийн саналын хэрэгцээ, шаардлага, үндэслэл, зорилго, зорилт, хүрэх үр дүн, техник, технологийн шийдэл, төслийн нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөлөл, зардал, үр ашиг, хэрэгжүүлэх арга замыг тоймлон тодорхойлоход чиглэгдсэн баримт бичиг байх бөгөөд тухайн төслийг цаашид нарийвчлан судлах, хэрэгжүүлэх эсэх болон хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргах үндэслэл болно.

1.4. Энэхүү аргачлал нь УХОХ-т тусгагдах хөрөнгө оруулалтын төслүүдийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийхэд мөрдөгдөнө.

Хоёр. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаанд хамрагдах төслүүд

2.1. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаанд УХОХ-т тусгагдах 10 тэрбумаас дээш өртөг бүхий дараах төслүүд хамрагдана. Үүнд:

2.1.1. Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлэлийн түншлэлийн хөрөнгөөр буюу Засгийн газрын оролцоотой хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийгэм-эдийн засгийн шинж чанартай зам тээвэр, барилга байгууламж, эрчим хүч, цахилгаан дулаан үйлдвэрлэл, мэдээлэлийн технологи зэрэг дэд бүтцийн төслүүд,

2.1.2. Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлэлийн түншлэлийн хөрөнгөөр буюу Засгийн газрын оролцоотой хөрөнгө оруулалтаар хэрэгжих нийгмийн шинж чанартай нийгэм хамгаалал, эрүүл мэнд, боловсрол, соёл, шинжлэх ухаан, аялал жуулчлал, байгаль орчны зэрэг төслүүд,

2.1.3. Улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр хувийн хэвшлэлийн түншлэлийн хөрөнгөөр буюу Засгийн газрын оролцоотой хөрөнгө оруулалтаар

хэрэгжих үйлдвэрлэлийн шинж чанартай хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлвэрлэл, боловсруулах үйлдвэр, уул уурхайн төслүүд.

Гурав. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

3.1. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа нь нарийвчилсан судалгаа хийх, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар оновчтой шийдвэр гаргахад чиглэгдсэн үнэн зөв, бодиттой мэдээ, мэдээлэл, тооцоо судалгаанд үндэслэгдсэн байна.

Дөрөв. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны аргачлал, хамрах хүрээ, агуулга

4.1. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа нь тухайн төслийн онцлогт тулгуурласан ажлын даалгаварт үндэслэгдэн гүйцэтгэгдэх бөгөөд "УХОХ боловсруулах нийтлэг журам"-ын 2.4-д заасны дагуу дараах үндсэн судалгаа, шинжилгээг хамрана. Үүнд:

- 4.1.1. Эрэлтийн шинжилгээ
- 4.1.2. Бодлогын шинжилгээ
- 4.1.3. Техник, технологийн шийдэл
- 4.1.4. Санхүү эдийн засгийн шинжилгээ
- 4.1.5. Эрсдэлийн шинжилгээ

4.2. Судалгааны ажлын хамрах хүрээ нь тухайн хөрөнгө оруулалтын төслийн онцлог шинж чанараас хамааран харилцан адилгүй боловсруулагдаж батлагдсан ажлын даалгаварт үндэслэх бөгөөд дээрх 4.1 заалтад тусгагдсан үндсэн судалгаа, тооцоог хамарсан дараах нийтлэг үйл ажиллагааны хүрээтэй байна. Үүнд:

4.2.1. Төслийн хэрэгцээ, шаардлага, хэрэгжүүлэх үндэслэлийг тодорхойлох: энэхүү хэсэгт тухайн төсөл хэрэгжих салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлууд, хэрэгцээ, шаардлага, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангах байдал зэргийг тодорхойлно.

4.2.2. Төслийн тодорхойлолт: Үүнд төслийн нэр, хэрэгжүүлэх салбар, байршил, төслийн хүрээнд дэвшүүлж буй зорилго, зорилт, хүчин чадал, техник, технологийн шийдэл, тодорхойлолт, төслийн үр өгөөж, гарах үр дүн, нийгэм-эдийн засаг, ядуурал, хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөөлөл, төслийн үр шимийг хүртэгчид, төслийн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын зардал, үйл ажиллагааны зардал, хэрэгжүүлэх хугацаа, хувийн хэвшлийн оролцооны боломж гэх зэргийг тодорхойлно.

4.2.3. Хөгжлийн бодлогыг хангах байдлыг тодорхойлох: Тухайн төсөл хэрэгжсэнээр хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрхэн хангахаар байгаа зэргийг тодорхойлно.

4.2.4. Санхүү, эдийн засгийн шинжилгээ: үүнд төслийн төсөвт өртөг, төслийн зардал, орлогыг тодорхойлох, зардал үр ашгийн тооцоо хийх, санхүү эдийн засгийн тооцоолол хийх, тэдгээрийн дүгнэлтийг тодорхойлно.

4.2.5. Төслийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох: төслийг хэрэгжүүлэх хувилбарыг тодорхойлох бөгөөд тухайн төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын эх үүсвэр, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх байгууллага, институцийн тогтолцоо, менежментийг тодорхойлно.

4.2.6. Эрсдлийн шинжилгээ: үүнд төслийн хэрэгжилтийн явц болон хэрэгжиж дууссаны дараа учирч болох эрсдэлийг тодорхойлж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн арга, хувилбаруудыг тодорхойлно.

4.2.7. Санал, зөвлөмж: Үүнд судалгааны ажлын эцсийн дүгнэлт буюу төсөл хэрэгжүүлэх шийдвэрийг гаргахтай холбоотой дүгнэлт, санал зөвлөмжийг тодорхойлно. Түүнчлэн энэ хэсэгт тухайн төсөлд нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах шаардлагатай бол ТЭЗҮ боловсруулахад зайлшгүй авч үзэх асуудлуудын талаарх санал зөвлөмжийг тусгана.

4.3. Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны баримт бичиг нь дээр дурьдсан 3.2-т заасан нийтлэг үйл ажиллагааг хамарсан дор дурьдсан ерөнхий агуулгатай байна. Үүнд:

№	Агуулга	Тайлбар
<i>Нэг. Ерөнхий</i>		
1.1.	Төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааны үндэслэл	Үүнд тухайн төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгааг хийх хэрэгцээ, шаардлага үндэслэлийг тодорхойлон бичнэ. Тухайлбал УХОХ-т тухайн төслийн тусгагдах байдал, судалгааны ажлыг хэрэгжүүлэх захиалга, гэрээ, ажлын даалгавар, судалгааны ажлын товч танилцуулга зэргийн талаар бичнэ.
1.2.	Судалгааны ажлын зорилго, зорилт	Үүнд судалгааны ажлаар дэвшүүлсэн зорилго, зорилтуудыг тодорхойлон бичнэ.
1.3.	Судалгааны ажлын хамрах хүрээ	Тухайн судалгааны ажлын хамрах хүрээ, судалгааны баримт бичгийн бүтэц, агуулгын товч тайлбарыг тодорхойлно.
1.4.	Судалгааны арга зүй	Судалгааны ажлыг гүйцэтгэсэн арга зүйг тодорхойлно.
1.5.	Судалгааны ажлын даалгавар, хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө	Энэхүү хэсэгт судалгааны ажлын даалгавар, хэрэгжүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөө, хэрэгжүүлж гүйцэтгэсэн хугацааны талаар бичнэ.
1.6.	Судалгааны баг	Судалгааны ажлыг хэрэгжүүлсэн багын бүрэлдэхүүн, гүйцэтгэсэн ажил, үүргийг тодорхойлон бичнэ.
<i>Хоёр. Төслийн орчны шинжилгээ:</i>		
2.1.	Төсөл хэрэгжих салбар	Энэхүү хэсэгт төслийг хэрэгжүүлэх салбарын хөгжлийн чиг хандлага, хууль, эрх зүйн орчин, улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил дэхь хувь нэмэр, салбарын сүүлийн жилүүдийн хөгжил, салбарын хэрэгцээ, шаардлагыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, институцийн

		тогтолцоо, санхүү, хөрөнгө оруулалтын нөхцөл боломжийн талаарх асуудлуудыг хамруулан тодорхойлно.
2.2.	Төсөл хэрэгжих салбарын хэрэгцээ, шаардлага, тэдгээрийг хангах арга зам, боломж	Үүнд төсөл хэрэгжих салбарын хөгжилд тулгамдаж буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэгдсэн бодлого, зорилго, зорилтууд, хэрэгжилтийг хангахад чиглэгдэн авч буй арга хэмжээ, төсөөлөгдөж буй үр дүн, боломж, байж болох эрсдэл, салбарт хэрэгжиж байсан хөгжлийн төслүүдийн туршлагаас авсан сургамж зэрэгт дүгнэлт гаргана.
<i>Гурав. Санал болгож буй төсөл</i>		
<i>3.1. Ерөнхий:</i>		
3.1.1.	Үндэслэл	Үүнд төслийг хэрэгжүүлэх бодит хэрэгцээ, шаардлага болон хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангах байдалд үндэслэн товч тодорхойлно.
3.1.2.	Төслийн зорилго, зорилт	Тулгамдаж буй асуудлыг төслийн хүрээнд шийдвэрлэх зорилго, зорилтуудыг тодорхойлно.
3.1.3.	Төслийн үр дүн	Төсөл хэрэгжсэнээр гарах үр дүнгийн талаар товч тодорхойлон бичнэ.
<i>3.2. Төслийн тодорхойлолт:</i>		
3.2.1.	Эрэлтийн шинжилгээ	Төслөөр дэвшүүлж буй зорилго, зорилтын үндэслэлийг тодорхойлоход чиглэгдсэн төслийн бодит хэрэгцээ, шаардлагыг эрэлтийн шинжилгээгээр тодорхойлно.
3.2.2.	Хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангах байдал	Тухайн төсөл нь улс орны болон салбарын хөгжлийн бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг хэрхэн хангахаар байгаад дүгнэлт гаргана.
3.2.3.	Төслийн техник, технологийн шийдэл	Төслийг үр дүнтэй, чанартай хийж гүйцэтгэхэд чиглэгдсэн техник, технологийн шийдлийг тодорхойлсон холбогдох тооцоо, судалгаа, төслийн бүрдэл хэсэг, техник, технологийн шийдэлд үндэслэгдсэн төслийг хэрэгжүүлэх хугацаа зэргийг хамруулна.
3.2.4.	Төслийн хөрөнгө оруулалтын тооцоо, хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах шаардагдах хөрөнгө оруулалтын зардал, ашиглалтын зардлын тооцоо, судалгаа, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн боломжит хувилбар (улсын төсөв, зээл, тусламжийн хөрөнгө, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт гэх мэт)-ын тооцоо, түүнчлэн тухайн төслийн техник, технологийн онцлогт үндэслэсэн хөрөнгө оруулалтын санал болгох хуваарь зэргийг хамруулна.
3.2.5.	Төсөл хэрэгжүүлэх институцийн тогтолцоо, удирдлага зохион байгуулалт	Тухайн төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх институцийн тогтолцоо, хэрэгжүүлэгч байгууллагын туршлага, чадавхи, удирдлага зохион байгуулалтын талаарх холбогдох тооцоо, судалгааг хамруулна.
3.2.6.	Төслийг хэрэгжүүлэх арга зам, хувилбар	Үүнд төслөөр дэвшүүлж буй зорилго, зорилтыг үр дүнтэй хангахад чиглэгдсэн төслийг хэрэгжүүлэх

		арга зам, хувилбарыг тодорхойлно. Үүнд техник, технологийн шийдэл, санхүүжилтийн хэлбэр (улсын төсөв, ТХХТ, Зээл тусламж гэх мэт), төслийг хэрэгжүүлэх менежмент гэх зэргийг бүрэн хамруулан тодорхойлно.
3.2.7.	Төслийн үр дүн	Тухайн төслийг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн талаар хийгдсэн холбогдох тооцоо, судалгааг дэлгэрэнгүй тодорхойлон бичнэ. Мөн төсөл хэрэгжээгүй нөхцөл үүсч бий болох үр дүнг тодорхойлно.
3.2.8.	Төслийн үр нөлөө	Төсөл хэрэгжих явц болон хэрэгжиж дууссаны дараах эдийн засаг, нийгэм, төсөл хэрэгжих салбар, хүрээлэн буй орчин, байгаль орчинд гарч болох эерэг болон сөрөг нөлөөллийн талаарх холбогдох тооцоо, судалгааг хамруулан тусгана.
<i>Дөрөв. Төсөл хэрэгжих боломж, эрсдэл</i>		
<i>4.1. Санхүү, эдийн засгийн шинжилгээ:</i>		
4.1.1.	Төслийн орлого, зарлага	Үүнд төслийн санхүү, эдийн засгийн тооцооллыг хийхэд шаардагдах төслийн орлого, зарлагын тодорхойлолт, тайлбар болон орлого, зарлагын тооцоог тусгана.
4.1.2.	Санхүү, эдийн засгийн тооцоолол	Төслийн зардал үр ашгийн тооцоо, санхүүгийн болон эдийн засгийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ, дотоод өгөөжийн хувь хэмжээ, төслийн зардлаа эргэн төлөх хугацаа зэрэг тооцооллыг тусгана.
4.1.3.	Санхүү, засгийн шинжилгээний дүгнэлт	Дээр дурьдсан тооцоолол, судалгааны дүгнэлт, тайлбарыг тусгана.
<i>4.2. Эрсдлийн шинжилгээ:</i>		
4.2.1.	Эрсдэлүүд	Төслийг хэрэгжүүлэх болон хэрэгжсэний дараа гарч болох эрсдлүүдийг тодорхойлохын дээр тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замуудыг тодорхойлно.
<i>Тав. Дүгнэлт, санал зөвлөмж</i>		
5.1	Дүгнэлт, санал зөвлөмж	Судалгааны ажлын дүгнэлтийг тодорхойлох бөгөөд тухайн төслийг нарийвчлан судлах, хэрэгжүүлэх эсэхэд чиглэгдсэн санал зөвлөмжийг боловсруулна.
5.2.	Цаашид асуудал судлах	Хэрэв судалгааны ажлын дүгнэлтээр тухайн санал болгож буй төслийг нарийвчлан судлах шаардлагатай буюу нарийвчилсан ТЭЗҮ хийх шаардлагатай гэж үзвэл нарийвчлан судалгаанд тавигдах шаардлагыг тодорхойлно.
<i>Зургаа. Хавсралтууд</i>		
	Хавсралт	Судалгааны ажилтай холбогдох хавсралт материалуудыг тусгана.